

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН**  
/2022.10.17 - 2022.10.21/

2022.10.07

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
<b>Барилга хот байгуулалтын хэлтэс</b>		
1	Барилга угсралтын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> <li>✓ Барилгын зөрчилтэй 2 барилга байгууламжид шаардлагыг тавьж арга хэмжээ авч ажилласан. Үүнд:               <ul style="list-style-type: none"> <li>- Дархан-Уул аймаг, Дархан сум, 5-р багт байрлалтай 4506903851 нэгж талбарын дугаартай “Мөнх зол улам дэлгэр” ХХК-ний автомашины засвар, үйлчилгээний газрын зориулалттай газартаа барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авалгүй барилга угсралтын ажил хийсэн.</li> <li>- Дархан-Уул аймаг, Дархан сум, 14-р багт байрлалтай 4505900723 нэгж талбарын дугаартай “Бэхч булган” ХХК-ний авто гаражийн зориулалттай газартаа барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авалгүй барилга угсралтын ажил хийсэн.</li> </ul> </li> <li>✓ Дархан-Уул аймгийн хэмжээнд барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөлгүй авалгүй барилга угсралтын ажил хийсэн, барилга байгууламжаа ашиглалтад оруулаагүй үйл ажиллагаа явуулж байгаа 20 объектийн судалгааг гаргаж холбогдох арга хэмжээг авч өгөх тухай албан бичгийг Мэргэжлийн хяналтын газарт өгсөн.</li> </ul>
1	Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Шарын гол сумын дулаан хангамж, цэвэр ус хангамж, бохир ус хангамжийн мэдээллийг Дулаан шарын гол ТӨХК-тай хамтран гаргаж шугам сүлжээний мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 10 сарын 17 өдрөөс 20 өдрийг дуустал ажиллаа. Дулаан цэвэр усны шугам – 8300м Бохир усны шугам – 10250 м Цэвэрлэх байгууламж</li> </ul>
	Барилгын материал үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> <li>✓ Барилгын хөгжлийн төвөөс батлагдсан №38/22 тоот удирдамжаар “Мэжик Нью Уорлд” ХХК-ний Дархан Уул аймаг, Дархан сум, 15-р баг, Мангирт 5-р хэсэг 326 тоот /4504502229/ 1412м<sup>2</sup> талбай бүхий Л.Гантовчийн гэр бүлийн хэрэгцээний өмчлөлийн зориулалттай газар барилгын хуванцар цонх, хаалга үйлдвэртэй очиж танилцан үнэлгээг шалгах хуудсаар бүртгэн үйлдвэрийн барилгын талбайд очиж үнэлгээг хийж ажилласан.</li> <li>✓ 2022.10.20-нд Барилга, барилгын материалын салбарын инженер техникийн ажилтнуудыг чадавхжуулах 0.5 кредит цагийн сертификаттай сургалтад хамрагдсан</li> </ul>
<b>Газрын удирдлагын хэлтэс</b>		
1	Суурь судалгаа, газрын мониторинг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Захиалгат хянан баталгааны 24 тайлан баталгаажуулж 6 тайлан хянаж буцаасан.</li> <li>✓ Гео инженеринг сүрвэй ХХК-д зөвлөмж хүргүүлж ажилласан.</li> </ul>
<b>Захиргаа аж ахуйн чиглэл</b>		
1	Мэдээллийн технологи, нярав	<p><b>Мэдээлэл:</b> 70376471 нээлттэй утсаар 8, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 5 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.</p> <p><b>Мэдээллийн технологи:</b> Байгууллагын цахим хуудасны Мэдээ, мэдээлэл хэсэгт Ган бүтээц /БНБД53-03-22/ норм ба дүрэм шинэчлэгдэн батлагдсан тухай мэдээг оруулав. Түгээмэл асуулт цэсний Суурь судалгаа, мониторинг хэсэгт Хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын мэдээллийг шинэчлэв. Байгууллагын Фэйсбүүк хуудсанд Ган бүтээц /БНБД53-03-22/ норм ба дүрэм шинэчлэгдэн батлагдсан тухай мэдээ, Хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын мэдээлэл, ААНБ тоон гарын үсгийн төхөөрөмж ашиглан egazar.gov.mn цахим хуудас руу хэрхэн нэвтрэх тухай зааврын видеог оруулав. ААНБ тоон гарын үсгийн төхөөрөмж ашиглан egazar.gov.mn цахим хуудас руу хэрхэн нэвтрэх тухай зааврын видеоны эхийг бэлтгэв.</p> <p><b>Нярав:</b></p>

		Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 2 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 18 ширхэгийг хүлээж авч бүртгэв. Шаардах хуудсаар 1 төрлийн 1.5 ширхэг бараа материал олгов.
--	--	--

Тайлан боловсруулсан:

Г.Нямдорж

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Г.Нямдорж